



## *Сургалт судалгаа*

### СЕМИНАРЫН ХИЧЭЭЛД ХЭРХЭН БЭЛТГЭХ ВЭ?

Сонсогчдод тусламж

Багш сонсогчдын зорилго чиглэлтэй, хамтын, идэвхитэй үйл ажиллагаагаар сургалтын үр дүн илэрдэг билээ. Оюутан сонсогчид семинарын болон бие даалтын хичээлд хэрхэн сайн бэлтгэж явуулснаас тухайн шинжлэх ухааны талаархи мэдлэг чадвар дадлага эзэмшиж үйл ажиллагаагаа жолоодон чиглүүлж чадна. Иймээс сургалт хүмүүжлийн ажилдаа зөв хандахад нь оюутан сонсогчдод туслах зорилгоор арга зүйн бяцхан зөвлөмжийг толилуулж байна.

Аливаа шинжлэх ухааны талаархи мэдлэг чадвар дадлыг эзэмших үйл явц нь:

- Оюутан сонсогчдод шинэ мэдлэг олгох
- Өгсөн мэдлэгийг ухамсарлан нэгтгэх
- Эргэцүүлэн сэргээх
- Практик дээр хэрэглэх гэсэн үе шаттайгаар явагдана.

Эдгээрийн эхний шатаас бусдыг нь оюутан сонсогч маань семинарын хичээл болон бие даан судлах замаар олж авдаг. Ингээд семинарын хичээлд хэрхэн бэлтгэснээр сүүлийн гурван шатыг эзэмших тухай өгүүлье.

Семинарын хичээлд бэлтгэхийн тулд төлөвлөгөө зохионо. Энэ төлөвлөгөөг тухайн шинэ мэдлэгийг олгож байгаа багш, эсвэл оюутан сонсогч өөрөө төлөвлөж болох юм. Ямарч тохиолдолд төлөвлөгөө дараах шаардлагыг хангасан байх учиртай. Үүнд:

- Тухайн сэдвийн хүрээнд судалбал зохих асуудлуудыг логик дэс дараалалтайгаар бичсэн байна. (энэ нь семинарын хичээлд бэлтгэхэд багшийн өгсөн асуулт байж болно)
- Семинарт бэлтгэхэд шаардлагатай уншиж тэмдэглэх эх зохиол, ном сурах бичиг, бусад материалыг номын сангийн бүртгэлээс шүүж жагсаах шаардлагатай
- Энэ сэдэвтэй холбогдсон арга зүйн зөвлөмжийг багшийн тусламжтайгаар бичиж тэмдэглэсэн байвал зохилтой.

Жишээлбэл **"Цэргийн сургалтын зарчмууд"** гэсэн сэдвээр хэрхэн семинарын төлөвлөгөө боловсруулахад тухайн сэдвийн хүрээнд судлах асуудлууд нь:

- Сургалтын зарчмын тухай ойлголт
- Цэргийн сургалтын зарчмын ач холбогдол, үүрэг, зорилго
- Зарчим тус бүрийн онцлог, тэдгээрийн хоорондын холбоо
- Зарчимд тавигдах шаардлага
- Практикт хэрэглэх арга зам гэх мэт байж болно.

Уншиж судлах ном, сурах бичиг, эх зохиол, бусад материалд:

- Л.Дамбийням "Офицерын ёс зүй" 1977 он УБ
- Б.Бор "Сургах хүмүүжүүлэх зүй" 1982 он УБ
- Л.Шагдарсүрэн "Сурган хүмүүжүүлэх ухааны зарим асуудал" 1985 он УБ
- Н.Пүрэвсүрэн "Цэргийн сурган хүмүүжүүлэх ухаан" альбом схем 1990 он УБ
- Г.Мягмаржав "Цэргийн сурган хүмүүжүүлэх ухааны үндэс" 1998 он УБ
- П.Даш "Их сургуулийн хэмжээнд боловсон хүчин бэлтгэнэ" "Хил судлал" сэтгүүл 1999№1

гэх мэтээр төлөвлөгөөнд тусгасан байвал асуултуудаа судалж боловсруулахад хялбар дөхөм байх болно.

Ийнхүү нарийн төлөвлөсний эцэст хэрэглэгдэх сурах бичиг, эх зохиолоо аваад семинарын хичээлд бэлтгэнэ. Үүнд:

- Холбогдох сурах бичиг эх зохиолоос шинэ материалын талаархи гол гол санааг ялган тэмдэглэж авна. Ингэхдээ шинжлэх ухааны бэлэн дүгнэлтийг зөвхөн мэдээллийн чанартайгаар хүлээж авах биш түүнийг нээж олсон арга зам, асуудал үүссэн шалтгаан, түүнийг шийдвэрлэхэд гарсан саад бэрхшээл гэх зэргээр алхам тутамдаа шинийг эрэлхийлэх маягаар хандах хэрэгтэй.
- Жишээ баримтуудыг татаж гол болон туслах ухагдахуунуудын ялгаа, хоорондын холбоог нотолж баталсан байх хэрэгтэй.
- Шаардлагатай тохиолдолд үндсэн асуудлын талаархи диаграмм таблиц, хүснэгт зэргийг өөрөө хийж бэлтгэнэ.
- Лекцээ уншиж сэргээн бодох
- Асуулт тавьж, өөрийнхөө үгээр ярьж сурах дадлага хийнэ
- Санаа бодол хувийн дүгнэлтээ бичиж тэмдэглэх зэргээр бэлдэнэ.

Семинарын хичээлд бэлтгэсний үр дүн хэрхэн илрэх тухай

товч өгүүлбэл:

- Шинжлэх ухааны талаархи мэдлэг тань систем дэс дараатай мэдлэг чадвар болсон байна.
- Бие даан сэтгэж ажиллах, нэгтгэн дүгнэх чадварыг эзэмшинэ.
- Ерөнхий мэдлэгийн хүрээг тань тэлж шинэ материалыг бие даан судлах боломжтой болно.
- Түүнийг практикт хэрэглэх арга замыг зөв сонгоно.
- Ном зохиол дээр бие даан ажиллаж танин мэдэхүйн шинэ арга барилыг эзэмшинэ.
- Эзэмшсэн мэдлэгээ хүнд ойлгуулах, өөрийгөө хянах, үнэлэх, дүгнэх чадвар эзэмшинэ.

Эцэст нь хэлэхэд та мэдлэг чадвар дадал эзэмших үйл явцаа чиглүүлэн жолоодож чадвал оюуны тань үйл эрч хүчтэй байх болно.

**Боловсрол судлалын магистр А.Туяа**

